



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар A/15

Улаанбаатар хот

Хэвлэмэл хуудас хүчингүй болгох тухай

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын 2.2.1.11, 4.3.6, Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга тэмдэг, баталгааны тэмдэг хэвлэмэл хуудас, хийлгэх журмын 6.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан Бэлчээрийн менежмент төслийн нэгж орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 2.3, 5.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хэвлэмэл хуудасны ашиглалт зарцуулалтын тооцоог гаргаж, найруулга зүйн болон хууль зүйн үндэслэл хангалтгүй хавсралтад дурдсан хэвлэмэл хуудсыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Хэвлэмэл хуудсыг үргүй зарцуулахгүй байх, стандартын шаардлага хангасан баримт бичиг боловсруулж ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.

3. Хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтын тооцоог жилийн эцсийн байдлаар гаргаж, Албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн (Д.Отгонмөнх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

3140000016